



УЛААНБААТАР ХОТЫН
УС СУВГИЙН УДИРДАХ ГАЗАР
ОНӨААТҮГ

Токиогийн 5 дугаар гудамж, 3 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976) 7015 7015
Цахим шуудан: usug1959@gmail.com
Цахим хуудас: www.usug.ub.gov.mn

2024.04.10 № 6/665

танай _____-ны № _____-т

Тодруулга

“А” болон “Б” ХХК нь манай байгууллагаас зарласан “Зөөврийн усан сан, сууц нийлүүлэх” нэртэй, УСУГ/20240102017 дугаартай тендерийн Багц №1: Нерж, хуванцар усан сан болон хуванцар усан сангийн сэлбэг нийлүүлэх тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолттой холбоотойгоор нэмэлт тодруулга авах тухай хүсэлт цахим системээр ирүүлсэн байна. Үүнд:

1.Хуванцар усан сан (8тн) гэсэн нь ямар материалаар хийгдсэн нөөцийн сав бэ? FRP хятад сав уу?, GRP солонгос сав уу? мөн хуванцар усан сангийн сэлбэгүүд нь FRP юу GRP солонгос савны сэлбэгүүд аль нь вэ?

2.Багц1: Нерж, хуванцар усан сан болон усан сангийн сэлбэг нийлүүлэх багцын нерж усан сангийн техникийн тодорхойлолтын маягтын 4-т заасан чанарын шалгуурт Стандарт хэмжил зүйн газар болон итгэмжлэгдсэн лабораторийн материалын сорьцын шинжилгээний дүгнэлт сертификаттай байх гэж заажээ. Манай компани нерж шинжлүүлэхээр Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа Номингийн лаборатори (18002888), Хими, химийн технологийн хүрээлэн (453133), Барилга Архитектур Корпораци (70131534), Хүнсний аюулгүй байдлын лавлагаа лаборатори (70005972)-т тус тус хандсан боловч шинжлэх боломжгүй гэсэн хариуг ирүүлсэн. Дээрх лабораториуд нь итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын дагуу бүтээгдэхүүнийг шинжилдэг бөгөөд нержийн шинжилгээ хийдэггүй юм байна.

Иймд энэ асуудлыг тодруулж өгнө үү?

Тодруулга:

1.Манай байгууллага дээр одоогоор хятад хуванцар усан болон хуванцар усан сангийн сэлбэг ашиглагдаж байгаа болохыг үүгээр мэдэгдэж байна.

2.Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа лабораториуд нь нерж

материал дээр шинжилгээ хийгдэхгүй байгаа тул тендерийн баримт бичигт заасан нерж усан сангийн техникийн тодорхойлолтын 4.Нийлүүлэгч нь Стандарт хэмжил зүйн газрын болон итгэмжлэгдсэн лабораторийн материалын сорьцын шинжилгээний дүгнэлт сертификаттай байх (тухайн жил шинээр авсан буюу баталгаажуулсан байх) гэсэн шаардлагыг тухайн санал болгож буй нерж усан сангийн үйлдвэрлэгчийн сертификат болон нержин материалыг шинжлүүлсэн шинжилгээний бичиг ирүүлэх гэж тус тус өөрчлөлт оруулж байгааг энэхүү тодруулгаар мэдэгдэж байна.